

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дамдинсүрэн	Дугаар	L232
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Сайхан сум
Төрсөн газар	Сайхан сум	Төрсөн он	1939
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Рашаантын хүрээ буюу Наваангүдэмбийн хүрээ	Сүм хийдийн дугаар	БУСХ 001
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-рсарын 26	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

Булган аймгийн Сайхан сумын Рашаантын хүрээ буюу Наваангүдэмбийн хүрээ

Д.Мөнхбат: За ингээд танд дараах асуултуудыг тавъя.Тэгэхээр энэ Рашаантын хүрээ маань хэдий үед байгуулагдсан юм , ямар хүн байгуулсан юм, ямар дэг жаягтай, ямар ямар хурал ном хурдаг, хичнээн ламтай, ямар ямар шүтээн сахиус залдаг хүрээ хийд байсан юм бол оо?

Дамдинсүрэн: Тэгэхээр би одоо үүнийг чинь сайн мэдэхгүй байна. Миний ижий ,аав бол сайн мэддэг байсан юм. Тэгэхээр одоо 1800... хэдэн оны үед юм бол би мэдэхгүй/ 70-аад оны үед юм болов уу гэж үргэлжлүүлэл/ тийм 1870-аад оны үед л юм бол уу даа би энийг мэдэхгүй.. Би чинь 1939 онд төрсөн хүн болохлоор... Миний ижий аавын ярьж байснаар бол одоо Наваан гэдэг хүн одоо төрөөд хүнээр ном заалгаагүй ээ, номыг бол өөрөө ном үзэж таньдаг ийм хүн байсан . Тэгээд одоо сүүлд нь хүрээ хийд байгуулаад лам нар зам нартаа одоо өөрөө ном заадаг юмуу эсвэл ... одоо ингэж байсан юмуу даа. За одоо тэгээд Богдоос очиж аравнай өргүүлж одоо нэр авсан байх юм. Одоо дацан хийд гэж.. Тэгэхээр одоо дацан гэдэг бол хүрээний одоо тэгээд юу юмаа...уншсан одоо тэр шүтээн. Тэхлээр одоо Ёг гэдэг дацан бол...Рашаантын хүрээ бол Ёг гэдэг дацантай байсан юм .Миний ижий аавын ярьж байгаагаар бол ёг гэдэг бол одоо их хатуу уншлагатай тийм байсаан. Наваан Гүдэн багш бол өөрөө их сурдаг хүн байсан бололтой юм. За тэгээд одоо энэ ёг гэдэг дацантай ёг гэдэг нэртэй овоог тахидаг одоо тийм байсан гэж л миний ижий аав ярьдаг даа. За тэгээд одоо яахав тэгэхлээр зэрэг Гүдэн багшийн чинь анхны номолж байсан байшин нь Гүдэн сүмээс олдсон одоо тэр байшинд .Тэгээд одоо тэр Гүдэн багшийг чинь занданшуулчихсан барьсан тэрлэг эд нар чинь байж байгаа. Одоо яг тэр чигээрээ. За одоо ингээд Наваан гэдэг хүн чинь ийм л түүхтэй одоо миний мэдэж байгаа нь энэ л байна.

Д.Мөнхбат: За тэгэхээр одоо энэ Наваан Гүдэн гэдэг хүн чинь одоо яг энэ нутгийн хүн биз тиймээ,

Дамдинсүрэн: Тийм, одоо манай ээжийн аавын ах болох хүн дээ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Тэгэхээр одоо энэ Рашаантын хийдээс бас нилээд лам , эрдэм чадалтай улсууд олон төрж гарсан гэж тэмдэглэгдсэн байдаг юм байна лээ.Тэгэхээр одоо Рашаантын хүрээг Наваан Гүндэн ламыг өнгөрсний дараа хэн толгойлж байсан, мөн одоо энэ Аграмба гэдэг хүнийг 13-р далай ламын багш ч болж байсан, шавь ч болж байсан гэж би үншиж байсан л даа . Та ч бас түрүүн яриандаа цухас дурдах шиг болсон. Энэ тухайгаа илүү дэлгэрэнгүй ярьж өгөхгүй юу?

Дамдинсүрэн: За Аграмба багш бол ингэж байсан. Гүдэн багш таалал болжээ...Гүдэн багш таалал болсны дараа Богдын хүрээнээс Аграмба багш ирж одоо ингэж энд хүрч ирээд Аграмбын Дамжаа барьжээ. Энэ Рашаантын хүрээнд, Аграмбын дамжаа бариад Дүйнхэр Ван тависан. Халхад Дүйнхэр Ван тависан монгол лам байхгүй .Мөн Аграмба багшаас хойш Халхад Аграмбын дамжаа барьсан хүн байхгүй.Одоо ч лам нар олон болсон. Дүйнхэр лам тавих лам нар олон байх л даа. Ийм л байна даа

Д.Мөнхбат: Аграмба багш тань 13-р далай ламтай багш шавийн харилцаатай байсан. Энэ нь Дайчин Вангийн хүрээн дээр энэ хоёр ламтан уулзахад илэрч байсан тухай ном сударт тэмдэглэсэн байдаг . Энэ тухай ярина уу?

Дамдинсүрэн: Алив нөгөө зураг хаана байна/ охин нь гуутай бүрхны араас эрт үеийн нэгэн хуучирсан фото зураг авч өгөв/ .За нөгөө миний яриад байгаа Аграмба багш маань энэ байна даа. Дандар Аграмба гэдэг хүн. 1900-аад оны эхээр юм гэнэ лээ. Яг хэдэн оныг нь би сайн мэдэхгүй байна. 13-р далай лам ар Халхад ирж манай Дайчин Вангийн хүрээнд морилжээ. Вангийн хүрээнд Аграмба багш далай ламыг хүлээж авч. Тэгээд Аграмба багш далай ламаас адис авах гээд мэхийтэл далай лам харин өөдөөс нь Аграмба багшаас адис авах гээд толгойгоо бөхийлгэсэн гэдэг. Тэгээд хоёулаа хоёр талаас толгойгоо нийлүүлэн мэндэлсэн юм гэнэ лээ.Гэхдээ энэ үеэр манай Аграмба багш далай ламын номын шавь болсон юм гэдэг. За тэр зун далай багш Вангийн хүрээнд бараг зусаад намар нь буцсан юм гэнэ лээ.

Д.Мөнхбат: За Рашаантын хүрээний гол шүтээн юу байсан юм бол?

Дамдинсүрэн: Улаан сахиус байсан юм уу даа...Улаан сахиус Дамдин Чойжоо.

Д.Мөнхбат: Хүрээнд ер нь хэд орчим лам сууж байсан юм?

Дамдинсүрэн: Байнгын сууж хурал хурдаг 80 гаруй 100 шахам ламтай байсан гэдэг.

Д.Мөнхбат: 1937, 1938 оны хүрээ хийд лам нарыг хэлмэгдүүлсэн тэр он жилүүдэд Рашаантын хүрээний лам нарыг баривчлахыг нь баривчилж , тараахыг нь тараачихаад хүрээ хийдийг тэр дор нь шатаагаад устгасан юм болов уу, эсвэл хүрээний сүм дуган хожим болтол байсан юм уу?

Дамдинсүрэн: Рашаантын хүрээнээс нэг ч лам баригдаагүй. Харин ганцхан Дашням Унзад гэдэг хүн баригдан 10 жилийн ял сонсоод 3 жил хоригдож Могодын хүрээнээс баригдаж ирээд ял эдэлж байсан Бүрхэг Дэндэв гэдэг их том биетэй хүн.. Одоо энэ Хадбаатар аварга шиг бие хаатай хүн байж. Тэр хүний ач тусаар засангаас оргож нутагтаа ирсэн юм. Сүүлчийн сүм дуганууд нь 70- аад оныг хүртэл байсан юм. Айлуудын барааны амбаар за сүүний заводын амбаар хүртэл болсон байсан.

Д.Мөнхбат: За танд баярлалаа. Таны өгсөн мэдээлэл манай судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.